



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн 2016 оны
үйл ажиллагааны үр дүн**

**ТАЙЛАНТ ОНД ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ
ХОЛБООТОЙ 19,1 САЯ ТӨГРӨГИЙН
ӨГЛӨГ ҮҮСГЭСЭН БАЙНА.**

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар3
Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-5
Дарга, тэргүүлэх аудитор	Бүлэг 1
М.Хуанган	<i>Үйл ажиллагааны төлөвлөлт, төсвийн зарцуулалтын талаар</i>
Аудитын менежер	1.1 Үйл ажиллагааны талаар6
Х.Женисбек	1.2 Үйл ажиллагааны төсвийн төлөвлөлт, бусад орлогын талаар8
Аудитор	1.3 Батлагдсан төсвийн зарцуулалтын талаар8
М.Айнур	1.4 Батлагдсан бүтэц орон тоо, цалингийн сангийн талаар12
2017 оны 6 дугаар сар	Бүлэг 2
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 94159291 дугаарын утсаар харилцана уу	<i>Өмч хөрөнгөнд тавих дотоод хяналтын талаар</i>
ХАЯГ:	2.1 Өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар13
Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар 108 тоот өрөө	2.2 Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан талаар13
	2.3 Өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, зарцуулалтанд тавьж буй дотоод хяналтын талаар14
	2.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар15
	Дүгнэлт.16
	Зөвлөмж17
	Холбогдох байгууллагын санал:
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал22
	Саналд өгсөн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

ᠠᠭᠠᠭᠠᠨ ᠪᠠᠶ᠋ᠠᠨ-ᠣᠯᠭᠢᠨ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠸᠠᠨᠠᠭᠠᠨ ᠭᠠᠰᠢᠷᠢᠨ ᠤᠯᠤᠰᠤᠨ:

ҮАГ-ын харьяа Баян-Өлгий аймгийн Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Аудитын зорилт:

Монгол Улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн ИТХурлын захиалгын дагуу, Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн 2016 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг сайжруулах, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх дүгнэлт, зөвлөмж гарган үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго оршино.

Хамарсан хүрээ:

Гүйцэтгэлийн аудитад Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн 2016 оны төсвийн зарцуулалт, үйл ажиллагааг хамруулж Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Холбогдох яамнаас гаргасан холбогдох шийдвэрүүд, зохион байгуулсан ажлын үр дүн, хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн болон ажлын тайлан, бичиг баримтууд хамрагдлаа.

ᠠᠭᠠᠭᠠᠨ ᠪᠠᠶ᠋ᠠᠨ-ᠣᠯᠭᠢᠨ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠠᠸᠠᠨᠠᠭᠠᠨ ᠭᠠᠰᠢᠷᠢᠨ ᠤᠯᠤᠰᠤᠨ:

Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтэс нь 2016 онд 495,9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материалд тулгуурлан хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Аудитын арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд тусгагдсан аудитын арга зүйг ашиглан холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтан, хариуцсан мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, эрх зүйн байдлыг бодит байдалтай харьцуулах, байгууллагын үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын төлөвлөгөө, хөтөлбөр болон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт зөвлөмж боловсруулав.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

- 9.1 Төсвийн тухай хууль
9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9.2 НББ-ийн тухай хууль
9.3 Бусад хууль тогтоомж, эрхийн акт

Àóäèò òèéõ áàãèéí áċđýëäõċċí:

Аудитыг аймгийн Төрийн аудитын газрын аудитор М.Айнур ахалж, аудитор Х.Манаргул нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 2017 оны 05 сарын 01-нээс 5 сарын 30-ны хооронд ажлын 22 хоногт багтаан хийж гүйцэтгэхээр байсан боловч гүйцэтгэлийн аудит хийж байх хугацаанд өөр бусад судалгаанд ажилласан учраас аудитын хугацааг ажлын 8 хоногоор сунгаж ажиллав.

Бүлэг 1

**Тайлант онд үйл ажиллагаатай холбоотой
19,1 сая төгрөгийг өглөг үүсгэсэн байна.**

Оршил

Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зардлын гүйцэтгэлийг хангах, нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд олгох ажлыг зохион байгуулах, үйлчилгээг сайжруулах, эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад хуулинд заасны дагуу дэмжлэг үзүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий төсөвт байгууллага юм.

2016 онд нийгмийн даатгалд нийтдээ 86027 хүн хамрагдсан ба үүний 12500 нь даатгуулагч, 4377 нь сайн дурын даатгуулагч, 60020 нь төр хариуцах иргэд, 9130 нь малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна. Даатгал төлөгч аж ахуйн нэгжийн тоо 540 байна.

Тайлант онд нийгмийн даатгалын санд нийтдээ 16034,3 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөөтэй ажилласан байна.

1.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны талаар.

1.1 Үндсэн үйл ажиллагааны талаар.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 99,4 хувиар биелүүлсэн байна.

ЭМНДХэлтсийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг оны эхэнд боловсруулан, аймгийн Засаг даргаар батлуулан ажилласан байна.Төлөвлөгөөг орон нутагт хэрэгжүүлэхэд дөхөм болгох үүднээс төр засгийн бодлого, шийдвэр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, төрөөс тэтгэврийн талаарх баримтлах бодлого, хуулийн өөрчлөлт, шинэчлэлттэй уялдуулан боловсруулжээ.

Төлөвлөгөөнд хэрэгжүүлэх ажлуудыг дотоод зохион байгуулалтын ажлууд, тайлан мэдээ, судалгаа, мэдээллийн бааз бүрдүүлэх, хяналт шалгалтын ажлууд, бусад ажлууд гэсэн үйл ажиллагааны 4 чиглэлээр төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.Хууль хэрэгжүүлэх ажлуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2016 онд 16034,3 сая төгрөгийн орлогыг оруулахаар төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 15946,1 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөгөө 99,4 хувиар биелүүлсэн байна.

Нийгмийн даатгалын санд оруулсан орлогын бүтцийг авч үзвэл: тэтгэврийн даатгалын шимтгэлээс 9305,3 сая төгрөгийг буюу 58,3 хувийг, тэтгэмжийн

даатгалын шимтгэлээс 1049,2 сая төгрөгийг буюу 6,6 хувийг, ҮОМШ өвчний даатгалын шимтгэлээс 821,0 сая төгрөгийг буюу 5,1 хувийг, ажилгүйдлийн даатгалын шимтгэлээс 249,3 сая төгрөгийг буюу 1,7 хувийг, эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс 4521,2 сая төгрөгийг буюу 28,3 хувийг тус тус оруулсан байна.

Нийгмийн даатгалд тайлант онд нийтдээ 540 аж ахуйн нэгж, 86027 даатгуулагч хамрагджээ.Үүнд: даатгуулагчийн тоо 12500, сайн дурын даатгуулагч 4377, малчид 4200, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил эрхлээгүй иргэн 4930, төр хариуцах даатгуулагчдын тоо 60020 байна.Энэ нь 2014 онд нийгмийн даатгалд хамрагдсан хүний тооноос 4891 хүнээр, 2015 онд хамрагдсан хүний тооноос 2165 хүнээр тус тус илүү байна.

Тайлант онд Нийгмийн даатгалын сангийн үйлчилгээнд 71737 хүн хамрагдаж, нийтдээ 46279,1 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулжээ.Тодруулбал: тэтгэврийн даатгалд 14026 хүн хамрагдаж 39895,7 сая төгрөгийн, тэтгэмжийн даатгалд 2078 хүн хамрагдаж 1682,8 сая төгрөгийн, ҮОМШӨ-ний даатгалд 125 хүн хамрагдаж 612,3 сая төгрөгийн, ажилгүйдлийн даатгалд 167 хүн хамрагдаж 260,9 сая төгрөгийн, ЭМД-ын үйлчилгээнд 55341 хүн хамрагдаж 3827,4 сая төгрөгийн хөрөнгийг тус тусын сангаас зарцуулжээ.

Тэтгэврийн даатгалын санд 14026 хүн хамрагдсаны 7297 нь өндөр насны, 5156 нь тахир дутуугийн, 1573 нь тэжээгчээ алдсаны тэтгэмж авсан байна.

Нийгмийн даатгалын хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг сурталчилан ажилласны үр дүнд нийгмийн даатгалд хамрагдсан хүний тоо болон орлого нэмэгдэхэд тодорхой хэмжээнд нөлөөлсөн байна.Тухайлбал:

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг хэрэгжүүлснээс хойш нөхөн даатгалд 16165 хүн хамрагдаж, нөхөн даатгуулсан хугацааны шимтгэлээр тэтгэврийн даатгалын санд 39,5 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.Нөхөн даатгалын хуулиар 2016 онд даатгуулсан жилээр нэмэгдүүлэн 12 хүн тэтгэврээ өөрчлөн тогтоолгож, шинээр 28 хүн тэтгэвэр тогтоолгожээ.

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг сурталчилж, хэрэгжүүлэн ажилласнаар 43 аж ахуйн нэгж, байгууллагаас 318 хүн нийгмийн даатгалд нөхөн хамрагдаж, нийгмийн даатгалын санд 108,0 сая төгрөгийг нөхөн төлсөн байна.

Тус хэлтсийн Хяналт шалгалтын тасаг нь тайлант онд хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ.Үүнд:

-1 сум, 12 аж ахуйн нэгжид шалгалт хийж, 23,8 сая төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлж, 15,1 сая төгрөгийн алданги ногдуулж, нийт 38,4 сая төгрөгийн актыг барагдуулжээ.

-Тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолтонд байнгын хяналт тавьж, 12634 хүний материалыг шалгаж, 4 хүнд 16,5 сая төгрөгийн акт тавьж, 15,3 сая төгрөгийн төлбөрийг барагдуулжээ.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтарч, 12,7 сая төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

-Тэтгэвэр олголтын байдлыг арилжааны банкуудтай хамтран ажиллаж, улирал тутам 1 сая төгрөгөөс дээш болон 3 сарын хугацаагаар тэтгэврээ аваагүй тэтгэвэр авагчдын судалгааг гаргуулан, 4 хүний 3,5 сая төгрөгийг тэтгэврийн санд татан төвлөрүүлжээ.

-Ажилгүйдлийн тэтгэмжийн бодолтыг даатгуулагч тус бүрээр хянаж, ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа хугацаандаа ажил орсон 2 хүний 2,3 сая төгрөгийг санд буцаан төвлөрүүлжээ.

-Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгосон санхүүжилтийг шалгаж, “Нурлы”, “Фатиха” зэрэг хувийн эмнэлгүүдэд санхүүжилтийг буруу олгож ирснийг залруулж, 16,7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд иргэд, даатгуулагчдаас нийт 125 өргөдөл гомдол, санал хүсэлт ирүүлснийг бүртгэлд авч, холбогдох шийдвэрийн дагуу хуулийн хугацаанд хариуг өгсөн байна. Хэлтсийн дэргэдэх Гомдлын шаардлагын зөвлөлийн хурлыг 4 удаа хийж, 18 иргэний өргөдөл гомдлыг хэлэлцүүлж, 13 иргэний өргөдөл гомдлыг шийдвэрлэжээ.

Хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, судалгааг тухай бүр гаргаж, холбогдох газарт хүргүүлж ажилласны дээр Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулах мэдээллийг тухай бүр шилэн дансны нэгдсэн вэб сайтад байршуулсан байна.

1.2 Үйл ажиллагааны төсвийн төлөвлөлт, бусад орлогын талаар.

Тайлант оны үйл ажиллагааны төсвийг өмнөх оноос бууруулж баталсан байна.

Эрүүл, мэнд Нийгмийн даатгалын хэлтсийн 2016 оны үйл ажиллагаанд анх 465,8 сая төгрөгийн төсөв баталсан байна. Тодотгосон төсвөөр үйл ажиллагаанд 476,2 сая төгрөгийн, хөрөнгийн санхүүжилтэнд 25,0 сая төгрөгийн төсөв батлагдаж, нийт 501,2 сая төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулахаар тусгажээ.

Хэлтсийн сүүлийн 3 жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулж судалгаа хийж үзэхэд дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/						
Зүйл анги	2014 оны төлөвлөгөө	2014 оны гүйцэтгэл	2015 оны төлөвлөгөө	2015 оны гүйцэтгэл	2016 оны төлөвлөгөө	2016 оны гүйцэтгэл
Цалин хөлс, нэмэгдэл урамшил,НДШ	357,500.8	357,351.6	402,766.7	402,766.7	358,424.0	358,424.0
бараа үйлчилгээний бусад зардал	87,030.7	79,997.90	89,959.70	86,013.40	117,747.4	113,464.0
Хөрөнгийн санхүүжилт	151,200.0	151,200.0	78,100.0	77,729.0	25,000.0	24,100.0
Зардлын нийт дүн	595,731.5	588,549.5	570,826.4	566,509.1	501,171.4	495,988.0

Тус хэлтсийн үйл ажиллагаанд 2014 онд 595,7 сая төгрөгийн, 2015 онд 570,8 сая төгрөгийн, 2016 онд 501,2 сая төгрөгийн төсөв батлагдсан ба үүнээс үйл ажиллагааны урсгал зардалд 2014 онд 444,5 сая төгрөгийн, 2015 онд 492,7 сая төгрөгийн, 2016 онд 476,2 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Хүснэгтээр нэгтгэж харвал:

Зүйл анги	2014 оны төлөвлөгөө	2015 оны төлөвлөгөө	2016 оны төлөвлөгөө	2014-2016 оны зөрүү	2015-2016 оны зөрүү
Цалин хөлс, нэмэгдэл урамшил,НДШ	357,500.8	402,766.7	358,424.0	923.2	- 44,342.7
бараа үйлчилгээний бусад зардал	87,030.7	89,959.70	117,747.4	30,716.7	27,787.7
Зардлын нийт дүн	444,531.5	492,726.4	476,171.4	31,639.9	- 16,555.0

Хөрөнгийн санхүүжилт 2014 онд 151,2 сая төгрөгийн төсөв батлагдаж байсан ба 2015 онд 73,1 сая төгрөгөөр, 2016 онд 53,1 сая төгрөгөөр буурсан байна.

Урсгал зардлын төсвийг өмнөх онтой харьцуулахад 2015 онд 48,2 сая төгрөгөөр нэмэгдэж, 2016 онд 16,5 сая төгрөгөөр буурч батлагджээ.Үүнд цалин хөлс, урамшууллын зардлыг урьд оноос 44,3 сая төгрөгөөр бууруулж, бараа үйлчилгээний зардлыг 27,8 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ.

Гүйцэтгэлээр 2014 онд 437,3 сая төгрөгийн, 2015 онд 488,8 сая төгрөгийн, 2016 онд 471,9 сая төгрөгийн төсвийг үйл ажиллагаанд зарцуулсан ба 2015 оны гүйцэтгэл урьд оноос 51,5 сая төгрөгөөр өсч, 2016 оны гүйцэтгэл урьд оноос 16,9 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна.

1.3 Батлагдсан төсвийн зарцуулалтын талаар.

Тайлант онд үйл ажиллагаатай холбоотой 19,1 сая төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс нь 2016 онд урсгал зардалд 471,8 сая төгрөгийн, хөрөнгийн санхүүжилтэнд 24,1 сая төгрөгийн бүгд 495,9 сая төгрөгийн төсөв зарцуулж, батлагдсан төсвийг 5,2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэр дараах байдалтай байна.Үүнд:

/мянган төгрөг/

	Зүйл анги	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	322,904.6	322,904.6	-
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,519.4	35,519.4	-
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,914.3	16,159.3	- 4,755.0
4	Хангамж,бараа материалын зардал	9,951.8	9,750.6	- 201.2
5	Эд хогшил, урсгал засварын зардал	601.0	645.2	44.2
6	Томилолтын зардал	3,895.0	3,894.9	- 0.1
7	Нормын хувцас	-	-	-
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний ажил, үйлчилгээ	2,820.0	2,762.8	- 57.2

9	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	1,053.0	1,053.0	-
10	Зөвлөл, хороо комиссын гишүүдийн ажлын хөлс	28,586.1	28,586.1	-
11	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, тэтгэмж	50,646.2	50,612.2	- 34.0
12	ХӨРӨНГИЙН САНХҮҮЖИЛТ	25,000.0	24,100.0	- 900.0
	Нийт дүн	501 171,4	495 988,1	5,183,3
13	Нийгмийн даатгалын сангаас	476,171.4	471,888.2	4,283.2
14	Хөрөнгийн санхүүжилт	25,000.0	24,100.0	900,0

Зардлын зүйл ангиар авч үзэхэд: цалин хөлс, нэмэгдэл урамшал, нийгмийн даатгалын шимтгэл, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал, зөвлөл, хороо комиссын гишүүдийн ажлын хөлс зэрэг зардлуудыг төсөвтөө багтаан бүрэн зарцуулжээ.

Харин байр ашиглалтын зардал, хангамж бараа материалын зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардал, ажил үйлчилгээний зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал зэрэг зардлуудыг 34,0-4755,0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал дотор халаалтын зардал 4,0 сая төгрөгөөр хэмнэгджээ. Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй 4283,2 мянган төгрөгийн үлдэгдлийг харьяа дээд газарт төвлөрүүлсэн байна.

Оны эцэст нийтдээ 35,9 сая төгрөгийн өгтэй гарсаны 7,9 сая төгрөгийг ХХОАТатварын, 11,2 сая төгрөгийг НДШ-ийн, 16,8 сая төгрөгийг үнэт цаасны өглөг эзэлж байна.

Үйл ажиллагаатай холбоотой өглөг өмнөх оноос 17,2 сая төгрөгөөр өссөн нь цалингийн сан дутуу батлагдсантай холбоотой байна.

Оны эхэнд үнэт цаасны тооцоотой холбоотой 12,6 сая төгрөгийн өглөгтэй ба тайлант онд Ерөнхий газраас 17,4 сая төгрөгийн үнэт цаас хүлээн авч, үнэт цаасны орлогоос 13,6 сая төгрөгийг, лавлагааны орлогоос 0,3 сая төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст 16,8 сая төгрөгийн өглөгтэй гарч, тооцоо нийлсэн байна.

Шүүхийн шийдвэрээр Ш.Сакений цалинд 5,3 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж буюу эмнэлэг, хөдөлмөрийн магадлалын зардлаас төлсөн байна.

Төсөвт суулгасны дагуу өндөр насны тэтгэвэрт гарсан 3 хүнд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тусламжийг зардлаас 43,8 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

Хөрөнгийн санхүүжилтээр хөрөнгө, эд хогшил худалдан авах үйл ажиллагааг ТБОНӨХБАҮХ авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу өөрсдөө зохион байгуулж, бага үнийн санал ирүүлсэн компаныг сонгон шалгаруулж 24,1 сая төгрөгийг зарцуулж, 0,9 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Гүйцэтгэлийн аудитын явцад зарим зардлуудын гүйцэтгэлийг түүвэрлэн шалгаж үзэхэд дараах байдалтай байна. Тухайлбал:

-Халаалтын зардалд 16,4 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 12,3 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 4,0 сая төгрөгөөр хэмнэжээ. Хэлтсийн байрны

талбайг 1033,4 м3-аар тооцож, үүнд 2014 онд худалдаж авсан өргөтгөл байрны 128,8 м3 талбайг нэмж, нийт 1162,2 м3 талбайд сард 1661,9 мянган төгрөгөөр “Эрчим баян” ХХК-тай гэрээ хийж, гэрээний дагуу 12,2 сая төгрөгийг төлсөн байна.Халаалтын зардлаас засвар үйлчилгээнд 150,0 мянган төгрөг зарцуулжээ.

-Цахилгаан, цэвэр бохир усны зардлын зарцуулалтанд зөрүү гараагүй.

-Тээвэр шатахууны зардалд 4,3 сая төгрөг төлөвлөгдсөн ба 2016 оны тодотгосон төсвийн хуваарьт тээвэр шатахууны төсвийн 2,1 сая төгрөгийг хэлтсийн албаны хэрэгцээнд, 2,1 сая төгрөгийг сумын байцаагчдад олгохоор тусгажээ.

Гүйцэтгэлээр шатахууны зардалд 6,2 сая төгрөгийг зарцуулснаас 4,3 сая төгрөгийг шатахууны төсвөөс, 1,9 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гаргасан байна.Төсвийн хуваарьт хөдөө сумын байцаагч нарт 2,1 сая төгрөгийн шатахуун зарцуулахаар хуваарилсан боловч үүнийг хэрхэн зарцуулах нь тодорхой бус байна.

Тайлант онд “НИК” ХХК-тай шатахуун нийлүүлэх гэрээтэй ажиллаж, нийт 6069,1 сая төгрөгийн шатахууны үнийг нэхэмжилснээс 6167,8 мянган төгрөгийг төлсөн байна.Өмнөх оны санхүүгийн тайланд шатахууны тооцоотой холбоотой өглөг тусгагдаагүй бөгөөд илүү шилжүүлсэн 98,8 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

2016 оны шатахууны зарцуулалтын тооцоог сар бүр зохих журмын дагуу хийгээгүй боловч аудитын явцад байгууллагын Iexus-470 маркийн машины 100 км-т зарцуулах шатахууны тооцоог адилтгах моторын багтаамж бүхий машинтай адилтгаж тооцоо хийж үзэхэд зөрүү гараагүй болно.

Зарим саруудад шатахууны талоны баримтын бүрдэлтийг хангаагүй баримтаар шатахуун олгож байсан, хөдөө сумуудад ажилласан замын хуудсанд албан томилолтын хуудсыг баримтжуулж хавсаргаагүй байна.Замын хуудсыг томилолтын хуудастай тулгаж үзэхэд хэлтсийн даргын 7, 9, 11 дүгээр сард Алтанцөгц, Ногооннуур, Булган Улаанхус сумдад явж ирсэн замын хуудсанд албан томилолтын хуудсыг баримтжуулж хавсаргаагүй байна.Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх” гэснийг хангахгүй байна.

Аудитын дүнгээр дээрхи зөрчил дутагдлыг арилгаж шатахууны талоныг хэвлэмэл хуудсаар олгож байх, хөдөө ажилласан тохиолдолд замын хуудсанд албан томилолтын хуудас, илтгэх хуудас зэрэг нотлох баримтуудыг бүрдүүлж хавсаргаж байхыг албан шаардлагаар үүрэг болголоо.

Тус хэлтсийн 2016 оны автомашины замын хуудсаар нийтдээ 16771 км зам явсны 12677 км-ыг буюу 75,6 хувийг хот дотор, 4094 км-ыг буюу 24,4 хувийг хөдөө сумд явсан байна. Шатахуун зарцуулалтыг Засгийн газрын 2015 оны 184 тоот тогтоолоор баталсан “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” журамд албан ажлын хэрэгцээний автомашины хот дотор явах хязгаарыг ажлын хоногт дунджаар 50 км–ээс хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар заасны дагуу автомашин замын хуудаснаас сар бүрийн хот дотор явсан км-ыг

түүвэрлэж үзэхэд хот дотор 5 сард 51 км, 6 сард 26 км, 8 сард 638 км, 9 сард 88 км, 11 сард 960 км, 12 сард 249 км нийтдээ 2012 км илүү явсан тооцоо гарч байна.

Аудитын дүнгээр Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 тоот тушаалаар баталсан “Автомашины 100 км гүйлтэнд зарцуулах шатахууны норм”, Төсвийн тухай хуулийн 41.2.3-т “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно” гэснийг хэрэгжүүлээгүй 6,2 сая төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоог хийгээгүй зөрчил дутагдлыг арилгах, шатахууны зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулж, холбогдох журмын дагуу өдөрт явах замын хязгаарыг 50 км-ээс хэтрүүлэхгүй байхыг албан шаардлагаар үүрэг болгов.

1.4 Батлагдсан бүтэц, орон тоо, цалингийн сангийн талаар.

Батлагдсан орон тоондоо багтаан ажилласан боловч цалингийн сан дутуу батлагдсан байна.

Тус хэлтэст 2016 онд 39 орон тооны 322,9 сая төгрөгийн цалингийн сан, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 35,5 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Гүйцэтгэлээр 38 орон тоогоор ажиллаж, 306,4 сая төгрөгийг үндсэн цалинд, 9,9 сая төгрөгийг унаа болон бусад нөхөн олговорт, 6,6 сая төгрөгийг гэрээт ажлын хөлст бүгд 322,9 сая төгрөгийг, ажил олгогчоос төлөх НДШ-д 35,5 сая төгрөгийг зарцуулжээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар цалингийн болон НДШ-ийн зардлыг бүрэн зарцуулсан боловч 11,2 сая төгрөгийг НДШ-ийн, 7,9 сая төгрөгийн ХХОАТ-ын өглөгтэй гарсан байна. Энэ цалингийн сан дутуу батлагдсантай холбоотой байна.

Гэтэл ажилчдад ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулалын зардлаас 4,5 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт олгож, төсвийн зарцуулагдаагүй 4,3 сая төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд өглөгийн тодорхой хэсгийг барагдуулах боломжийг ашиглаагүй байна.

Цалин тогтоолтыг түүвэрлэн шалгаж үзэхэд Нийгмийн Даатгалын ерөнхий газраас хэлтсийн даргын цалинг 2014 оны 10 дугаар сарын 01-нд тогтоосныг 2016 оны 4 дүгээр сарын 01-нийг хүртэл мөрдөж, Ерөнхий газрын даргын 5 дугаар сарын 17-ны өдрийн Б/100 тоот тушаалаар шинэчлэсэн байна.

НД-ын хэлтсийн даргын 2016 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн А/11 тоот тушаалаар албан хаагчдын цалинг шинэчилж тогтоосон ба цалин тогтоолт, олголтыг шалгаж үзэхэд зөрүү гараагүй.

Сар бүрийн цалингийн цэст ажилчдаар танилцсан гарын үсэг зуруулаагүй, цалингаас суутгал хийхдээ жагсаалт хийж зөвшөөрсөн гарын үсэг зуруулаагүй, зарим сард гарт олгох цалингаас суутгал хийж нярав болон зарим ажилчдын дансанд шилжүүлсэн зэрэг зөрчил дутагдлууд оршиж байна.

Цаашид сар бүрийн цалингийн цэст ажилчдын танилцсан гарын үсгийг бүрэн зуруулах, цалингаас суутгал хийсэн тохиолдолд жагсаалт үйлдэж зөвшөөрсөн

гарын үсэг зуруулж байх, цалингийн суутгалын тооцоог зохих журмаар хийхийг зөвлөлөө.

Аудитаар НДШ-ийн тооцоог хийж үзэхэд эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдэд олгосон 738,0 мянган төгрөгийн цалингаас НДШ-ийг ногдуулж суутгасан боловч байгууллагаас төлөх НДШ-ээс 99,0 мянган төгрөгийн шимтгэлийг дутуу төлж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй орхигдуулсаныг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Бүлэг 2

Анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөтлөлт шаардлага хангаагүй байна.

2.1 Өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар

Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналт хэвийн түвшинд байна.

Эрүүл, мэнд нийгмийн даатгалын хэлтэс нь нягтлан бодох бүртгэлийг “Санхүү” программаар хөтөлж, санхүүгийн тайлан, тодруулгыг програмаар гаргаж тайлагнасан байна. Байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг алдаа гаргаж, санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан байна.

Хэлтсийн даргын 2016 оны 12 сарын 22-ний өдрийн А/28 тоот тушаалаар жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө өмч, хөрөнгө, эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, бараа, материал, үндсэн хөрөнгийн тооллого, тооцоог хугацаанд нь хийж, үлдэгдлийг баталгаажуулжээ. Харьяа дээд байгууллагатай үнэт цаасны тооцоог хийж, тооцоо нийлсэн байна.

Жилийн эцэст Нийгмийн даатгалын хэлтэс, Татвар хэлтэс болон бусад бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд “НИК” ХХК, НААҮ-ний “Суат” ХХК, “Эрчим баян” ХХК, ЦШСГазар, Монгол шуудан, МЦХолбоо, мөн бичиг хэргийн болон сэлбэг худалдаалдаг хувийн компаниудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Тайлант онд харьяа дээд байгууллагаас 64,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, хөрөнгийн санхүүжилтээр 24,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэлд тусгажээ.

Төрийн өмчийн хорооны зөвшөөрлийн дагуу 9,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлээс хасч, тайлант онд үндсэн хөрөнгөнд нийт 36,3 сая төгрөгийн элэгдлийг байгуулсан байна.

2.2 Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан талаар

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Тус хэлтсийн 2016 оны төсөвт хөрөнгийн санхүүжилтэнд 25,0 сая төгрөг батлагдсан ба даргын 2016 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А/02 тоот тушаалаар ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Ажлын хэсгийн хурлаар худалдан авах ажлыг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу харьцуулалтын аргаар өөрсдөө зохион байгуулж, өмнөх тендер шалгаруулалтанд материал ирүүлж байсан 3 компанид урилга өгөхөөр шийдвэрлэсэн байна.

Үүний дагуу 3 компанид урилга явуулж, 2 компани үнийн санал ирүүлснээс хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Шынбулах” ХХК-ийг тендерийн гүйцэтгэгчээр шалгаруулжээ.Тавилга эд хогшил худалдан авах гэрээг 2016 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр хийж, өмч хамгаалах комиссын актаар 24,1 сая төгрөгийн тавилга, эд хогшил хүлээн авсан байна.

Аудитын явцад хэлтсийн даргын тавьсан хүсэлтийн дагуу 2014 онд худалдан авсан байрны өргөтгөлтэй холбоотой асуудлыг тодруулж шалгалаа.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтанд тус Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын өргөтгөлд 139,2 сая төгрөг батлагдсан байна.

Тус хэлтсийн даргын 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 60 дугаар тушаалаар төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.Комисс нь 2014 оны 7 дугаар сарын 07-ны өдөр хуралдаж, “Көшелик” ХХК-наас коридортой, 4 өрөө 128 м2 өргөтгөл байрыг худалдаж авахаар шийдвэрлэсэн байна.

Худалдан авсан “Көшелик” ХХК-ны өмчлөлийн 2003 онд ашиглалтанд орсон НД-ын хэлтсийн байрны залгаа 128 м2 талбайтай коридор бүхий 4 өрөө байрыг үл хөдлөх хөрөнгийн мэргэшсэн үнэлгээчин Х.Бекен 2014 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр үнэлгээ хийж, зах зээлийн үнэлгээгээр 140168,0 мянган төгрөгийн үнэтэй гэж тогтоосон байна.

Өргөтгөл байрыг худалдаж авах гэрээг 2014 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр байгуулж, 2014 оны 11 сарын 19-ны өдрийн 373 тоот албан бичгээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын төлөвлөлт, санхүү бүртгэлийн газарт худалдан авах гэрээ, холбогдох бусад баримтуудыг хүргүүлсэн байна.Дээд газрын зөвшөөрсний дагуу хөрөнгийн үнийг 2014 оны 12 сарын 10-ний өдөр шилжүүлж, үндсэн хөрөнгийг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 11 тоот баримтаар хүлээн авчээ.

2.3 Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтанд бүртгэлээр тавьж буй дотоодын хяналтын талаар.

Анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөтлөлт шаардлага хангаагүй байна.

Гүйцэтгэлийн аудитын явцад анхан шатны баримтын бүрдэл дутуу, журнал хөтлөөгүй зэрэг дараах зөрчил дутагдал илэрлээ.

Няраваар 6669,9 мянган төгрөгийн бараа материалын орлого, зарлагын баримт, шаардах хуудсуудыг үндэслэн батлагдсан маягтын дагуу бараа материалын тайлан гаргуулаагүй, шууд зардлаар бүртгэж ирсэн байна.Энэ нь Сангийн сайдын 2000 оны 69 дүгээр тушаалаар баталсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийн 16-д “мөнгөн хөрөнгө,бараа материал үнэт зүйлийг хүлээн авах, тавьж олгох, борлуулах ажлыг дагалдах баримт, хуваарь лимит зэргийг харгалзан өөрийн биеэр заавал шалган тоолж, гүйцэтгэх ба орлого, зарлагын баримт, анхан шатны бүртгэлийн заавар, баримт бичилтийн дүрмийн шаардлагын дагуу цаг тухайд нь цэвэр нямбай, засваргүйгээр үйлдэн өөрийн гарын үсгийг зурж баталгаажуулна”, 17-д “Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид

гарган өгч байна” гэсэн заалтуудыг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “журналд бичих”, 14.4.1-т “аж ахуйн бүх ажил гүйлгээ” гэснийг тус тус зөрчиж байна.

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар мөнгө олгосон, тооцоо хийсэн гүйлгээнүүд байна.Тухайлбал: -Зохион байгуулсан зарим нэг сургалтын зарцуулалтын анхан шатны баримтыг бүрдүүлээгүй, шагнал олгосон хүмүүст гарын үсэг зуруулж баримтанд хавсаргаагүй, зарим байцаагчдын томилолтын хуудсыг дүгнүүлээгүй, бэлнээр авсан томилолтыг хүлээн авсан талаар гарын үсэг зуруулаагүй, хотоос ачиж ирсэн үнэт цаас болон бусад ачааны үнэд төлсөн мөнгөний баримт материалыг бүрдүүлж хавсаргаагүй бүрдэл дутуу баримтаар мөнгө олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх” зэрэг заалтуудыг зөрчсөн байна.

Иймд илэрсэн зөрчлүүдийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байхыг албан шаардлагаар үүрэг болгов.

2.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Тус Аудитын газраас 2016 оны 11 сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад Эрүүл мэнд, НД-ын хэлтэс нь шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цэс нээж, бүртгэгдэн холбогдох мэдээллийг бүрэн байршуулж ирсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2016 оны эхний 11 сарын байдалд хийсэн нийцлийн аудитын дүнгээр зөрчил дутагдал гаргаагүй байна.

Гүйцэтгэлийн аудитаар 197,8 мянган төгрөгийн төлбөрийг нөхөн төлүүлэхээр акт тогтоож, 12,8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөгдлөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 99,4 хувиар биелүүлсэн байна.
2. Тайлант оны үйл ажиллагааны төсвийг өмнөх оноос бууруулж баталсан байна.
3. Тайлант онд үйл ажиллагаатай холбоотой 19,1 сая төгрөгийг өглөг үүсгэж, өрөө багасгах талаар санаачлагагүй ажилласан байна.
4. Батлагдсан орон тоондоо багтаан ажилласан боловч цалингийн сан дутуу батлагдсан байна.
5. Анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөтлөлт шаардлага хангаагүй байна.

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал ирүүлээгүй байна.

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.АЙНУР

АУДИТОР

Х.МАНАРГУЛ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал
(Аймгийн Засаг даргаас ирүүлсэн санал)